

## **ГУРАВ. ХӨТӨЛБӨРИЙН СУРГАЛТЫН ҮР ДҮНГҮҮД (PLO)**

### **3.1. Хөтөлбөрөөр эзэмших мэдлэг, чадвар, хандлага**

#### **1. Хувь хүний мэдлэг, чадвар, хандлага**

##### *1.1. Бүтээлчээр суралцах, өөрийгөө хөгжүүлэх*

- 1.1.1. Өөрийгөө таних, хөгжүүлэх, илэрхийлэх, хянах, бүтээлч шинжээ хөгжүүлэх
- 1.1.2. Бусдыг ойлгох, сонсох, хүндэтгэх, багаар хамтран ажиллах, мэдлэг түгээх
- 1.1.3. МХХТ-ийг хэрэглэх, цахим орчинд соёлтой, ёс зүйтэй оролцох, тасралтгүй суралцах
- 1.1.4. Мэдээлэл цуглуулах, боловсруулах, дүн шинжилгээ хийх, хэрэглэх, үнэлэх
- 1.1.5. Асуудалд шинжлэх ухааны үндэслэлтэй хандах
- 1.1.6. Биеэ дайчлан гадаад хэлний мэдлэгээ өргөжүүлэх, унших, ойлгох, харилцах, хэрэглэх

##### *1.2. Хэл, түүх соёлоо хүндэтгэх, түүгээр дэлгэрүүлэх, эрүүл аюулгүй амьдрах*

- 1.2.1. Эх хэлээрээ утга төгөлдөр, ойлгомжтой ярих, бичих, бүтээлчээр унших, харилцах
- 1.2.2. Эх түүх, соёл, ёс заншил, уламжлалаа тайлбарлах, бахархах, хэрэглэх
- 1.2.3. Соёлын ялгааг ойлгох, хүндэтгэлтэй хандах
- 1.2.4. Байгаль-хүн-нийгмийн шүтэлцээ, зүй тогтол, ТХБ-ын үзэл баримтлалыг тодорхойлох, хэрэгжүүлэх
- 1.2.5. Өөрийн болон бусдын эрүүл мэндийн төлөө санаа тавих, эрүүл аюулгүй орчин бүрдүүлэхэд санаачилгатай байх, эрүүл мэндээ хамгаалахад дэмжлэг үзүүлэх

##### *1.3. Бусадтай хамтран ажиллах, асуудлыг шийдвэрлэх*

- 1.3.1. Бүтээлч сэтгэлтэй, асуудлыг шийдвэрлэх, хамтран ажиллах, удирдан чиглүүлэх, дүгнэлт шийдвэр гаргах
- 1.3.2. Яриа хэлэлцээр хийх чадвар, хариуцлагаа ухамсарлах, хариуцлага хүлээх, дасан зохицох, цагийг зөв зохистой ашиглах
- 1.3.3. Үйлчлүүлэгч болон гэр бүл, эрүүл мэндийн баг, мэргэжилтнүүдийг ойлгох нарийн мэдрэмж байх
- 1.3.4. Шинэ санаа, шинэчлэлийг соргоогоор мэдрэх, зохицох, өөрчлөгдөх
- 1.3.5. Багийн алсын хараа, зорилго, зорилт болон үйл ажиллагаа төлөвлөлтийг зөв тодорхойлох, учирч болзошгүй саад бэрхшээлийг урьдчилан тооцох, багаар ажиллах зарчимд тулгуурласан эм зүйн тусламж үйлчилгээг үзүүлэх

#### **2. Мэргэжлийн суурь мэдлэг, чадвар, хандлага**

##### *2.1. Үйлчлүүлэгчийн онцлог, ялгаатай байдалд хандах хандлага, итгэл үнэмшил*

- 2.1.1. Нийгмийн гарал үүсэл, нас, хүйс, шашин шүтлэг, ёс заншил, арьс өнгө, нас, хүйсээр ялгаварлахгүй байх, үйлчлүүлэгч бүрийн хувийн болон насны сэтгэл зүйн онцлог, ялгаатай байдалд хүндэтгэлтэй хандах,
- 2.1.2. Үйлчлүүлэгч, түүний ар гэр, нийт хүн амд тохиолддог эрүүл мэндтэй холбоотой асуудлын өргөн мэдлэгтэй, клиник сэтгэлгээтэй, тэдэнд чин сэтгэлийн харилцаа тогтоож, хувь хүн бүрийн хэрэгцээ, итгэл үнэмшилд тохирсон, аюулгүй байдлыг хангасан, өвчнөөс урьдчилан сэргийлэх, эрүүл мэндийн зөвлөгөөг үнэн зөв өгөх, эм зүйн анхан шатны тусламж үзүүлдэг байх

##### *2.2. Мэргэжилтний үнэт зүйл, ёс зүй*

- 2.2.1. Эм зүйч ажилдаа чин сэтгэлээсээ ханддаг, ажил хэрэгч, хариуцлагатай, тууштай байх;
- 2.2.2. Эм зүйчийн нэр хүнд ёс зүйг эрхэмлэн төрийн хууль, дүрэм, журам мөрдөх, үлгэрлэх, манлайлах;
- 2.2.3. Үйлчлүүлэгчийн нууцыг хадгалах, мэргэжлийн ёс зүйн хэм хэмжээ, үүрэг хариуцлагыг ухамсарласан харилцаа, хандлагатай байх;

- 2.2.4. Удирдлага, эмч, ажилтан, хамтран ажиллагч болон бусад сонирхлын бүлгийн эрх ашгийг дээдлэх, байгууллагын сэтгэл зүйн таатай орчныг бүрдүүлэх, тэдгээрийг аливаа үйл ажиллагаанд татан оролцуулах, дэмжих;
  - 2.2.5. Байгууллагын ёс зүйн хэм хэмжээ, эрх ашгийг дээдлэх, нууцыг чандлан хадгалах, түншлэх;
  - 2.2.6. Хувь хүний эрхэм чанар, давтагдашгүй онцлог, ялгаатай байдал, нэр төрд хүндэтгэлтэй хандаж, түүний сайн сайхан байдлыг эрхэмлэх;
  - 2.2.7. Үнэнч шударга, тууштай байх, ажлын байрны зөв зохион байгуулалтыг төлөвлөх, хэрэгжүүлэх;
  - 2.2.8. Эм зүйн шинжлэх ухааны гүн бат мэдлэгтэй, зөөлөн ур чадварыг эзэмшсэн, чадварлаг, харилцаа хандлагыг эзэмшсэн байх.
- 2.3. *Эмнэл зүйн үйл явц, түүний хяналт шинжилгээний мэдлэг, чадвар, хандлага*
- 2.3.1. Ард иргэдэд эрүүл мэндийн болон эм зүйн тусламж үйлчилгээг үзүүлэхэд шаардагдах гадаад хэл, мэдээллийн болон техник технологийн ашиглалт, сэтгэл зүйн тусламж үйлчилгээг үзүүлэх;
  - 2.3.2. Эрүүл мэндийн хууль, тогтоол, дүрэм, журам, тушаал, шийдвэр, стандарт, технологи, эмнэлгийн тусламж үйлчилгээ үзүүлэх удирдамжийг мөрдөж ажиллах;
  - 2.3.3. Иргэний эрүүл мэндээ хамгаалах, өвчлөлөөс урьдчилан сэргийлэх, өвчин эмгэг, гэмтлийн улмаас эрүүл мэндэд үүсэх үр дагаврыг багасгах, арилгах чиглэлээр сургалт, сурталчилгаа хийх, эрүүл мэндийг дэмжих, арга хэмжээг зохион байгуулах.

### **3. Мэргэжлийн мэдлэг, чадвар, хандлага**

#### *3.1. Эм зүйн ухааны мэдлэг, чадвар, хандлага*

- 3.1.1. Мэргэжилийн хөгжилдөө анхаардаг, эм зүйн ШУ-г ахисан түвшинд судлан хөгжүүлдэг байх;
- 3.1.2. Эм хангамжийн байгууллагуудад олгож байгаа болон эмийн үйлдвэрт үйлдвэрлэж буй эмийн бүтээгдэхүүний чанар, аюулгүй байдалд хариуцлага хүлээх, аюулгүй, чанартай, баталгаатай эмийн бүтээгдэхүүнээр хангаж, түгээдэг байх;
- 3.1.3. Эмийн үйлдвэрт эмийн технологич, үйлдвэрлэлийн мастер, чанарын хяналтын менежер, эмийн шинжээчээр, эм ханган нийлүүлэх байгууллагад эмийн ерөнхий мэргэжилтэн-эм зүйчээр ажиллах чадамжтай байх;
- 3.1.4. Зах зээлийг судлах, сонгох, иж бүрэн арга хэмжээг хэрэгжүүлэх, маркетингийн хяналт, судалгаа, мэдээллийн систем, зах зээл судлалын микро ба макро орчин, тэдгээрийн эмийн зах зээл судлалын үйл ажиллагаанд нөлөөлдөг байх;
- 3.1.5. Шинэ бараа бүтээх, зах зээлд гаргах, түгээх, барааны үнийн бодлого, үнэ бүрдүүлэлт зэргийг судлан тооцоолдог байх;
- 3.1.6. Эмийн ургамлын түүхий эдийг зөв таньж тодорхойлон чанарын өндөр түвшинд бэлтгэх, савлах, тээвэрлэх, эрсдэлт хүчин зүйлээс хамгаалах, аюулгүй байдлыг хангах;
- 3.1.7. Эмийн түүхий эд, туслах материал, сав баглаа боодолд тавигдах чанарын стандартын шаардлагад нийцээгүй зүйлсийг хэрэглэхээс сэргийлэх;
- 3.1.8. Чанарын шинжилгээг үнэн зөв, хариуцлагатай хийх, протоколыг холбогдох журмын дагуу нягт нямбай хөтлөх, дүгнэх;
- 3.1.9. Багаж, төхөөрөмж, эмийн дээж, урвалж бодис, савтай зааврын дагуу зөв ажиллах, лабораторид ажиллах дүрмийг баримталдаг байх;

#### *3.2. Эм зүйн тусламж үйлчилгээний мэдлэг, чадвар, хандлага*

- 3.2.1. Эмийн эмчилгээг хянах, мэдээллээр ханган өвчтөнд тунгийн дэглэм уух арга замыг зөвлөдөг байх;

- 3.2.2. Үйлчлүүлэгчийн эрүүл мэндийг сайжруулахад тодорхой үр дүнд хүргэх тусламж үзүүлдэг байх;
- 3.2.3. Эмнэлгийн тусламж үйлчилгээнд эмийн тасалдал үүсгэх урьдчилан сэргийлэх, болзошгүй эрсдэлийг тооцоолдог байх;
- 3.2.4. Эм бэлдмэлийг өвчтөн бүрт зориулан нэгж тунгаар савлах, цаасан болон цахим жорын хяналт үнэлгээг хийдэг байх;
- 3.2.5. Хяналттай олгох эмийн бэлдмэлийг тусгай зориулалтын өрөө тасалгаанд цоожтой шүүгээнд хадгалж эмнэлгийн тасгуудын хуваарилалтад хяналт тавьдаг байх;
- 3.2.6. Хяналттай олгох эмийг өдөр тутмын бүртгэлийн дагуу шалган зөрчил алдааг тухай бүрт залруулан холбогдох арга хэмжээг авдаг байх;
- 3.2.7. Эмчлүүлэгчийн эмийн эмчилгээ, үл нийцэл, харшил эсрэг заалт, урьд өмнө тохиолдож байсан гаж урвалын талаарх мэдээлэлд чанарын албатай хамтран хяналт тавьдаг байх.